




МОНГОЛ, ЯПОН УЛСЫН БАГА БОЛОВСРОЛЫН ХӨГЖМИЙН ХӨТӨЛБӨРИЙН ШИНЭЧЛЭЛ

Г.Заяабат^а, Ч.Отгонбаяр^б, Hisako Watanabe^в

^аМУБИС-Багшийн сургууль, доктор;

^бМУБИС-Багшийн сургууль, доктор;

^в МУБИС-Багшийн сургууль, зочин багш

Холбоо барих зохиогч: zasaba@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2025.08.30

Хянагдсан: 2025.09.30

Зөвшөөрсөн: 2025.10.30

Хураангуй

Дэлхийн улс орнууд боловсролын бодлогын зорилгоо хүн төрөлхтний нийтлэг асуудлыг шийдвэрлэх чадвартай, мэдлэг, чадвар, зөв хандлагыг эзэмшсэн, бүтээлч, насан туршдаа суралцах чадамжтай иргэнийг төлөвшүүлэхэд чиглүүлж байна. Энэ зорилго нь зөвхөн агуулгын шинэчлэл төдийгүй боловсролын бүх түвшинд хандлагын өөрчлөлт шаарддаг.

Багшийн боловсролын олон улсын чиг хандлага нь хүмүүнлэг, нээлттэй, уян хатан тогтолцоог хөгжүүлэх, сургалтын үр нөлөөг нэмэгдүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлж байна. Үүний хүрээнд “Сургуулийн боловсролыг сайжруулж, илүү сайн нийгмийг бүтээх” зорилтыг дэвшүүлэн, сургууль, гэр бүл, орон нутгийн оролцогч талууд хамтран ажиллах, уялдаа холбоотой байх нь илүү үр дүнтэй боловсролын үндэс суурь гэж үзэх болжээ. Ийм нөхцөлд боловсролын хөтөлбөрийг “нийгэмд нээлттэй боловсролын хөтөлбөр” хэмээх шинэ чиг хандлагын дагуу шинэчлэн боловсруулж, сургалтын үйл явцыг илүү суралцахуйд чиглүүлэн, бодит оролцоонд суурилсан байхаар зорьж байна. Монгол, Япон улсын бага боловсролын хөгжмийн хөтөлбөрүүд ч энэ зорилгын хүрээнд шинэчлэгдэж, мэдлэг, чадвар, хандлагын төлөвшлийг уялдуулан тусгасан цогц агуулгатай болж байгаагаараа онцлогтой (сургууль, 2013).

Түлхүүр үг

Сургалтын хөтөлбөр, хөгжим, чадамж, суралцагч, хөтөлбөр, хүүхэд, ур чадвар

Удиртгал

Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал (2024-2036) зорилго нь суралцагчийн эзэмших чадамжийг тодорхойлж, эзэмшүүлэх сургалтын хөтөлбөр, судлагдахууны хөтөлбөрийн агуулгын залгамж холбоо, арга зүй, үнэлгээний нийцтэй байдлыг харгалзан боловсруулах үйл ажиллагааг чиглүүлэхэд оршино (тогтоол М. у., 2024).

Судалгааны асуудал:

1. Сургалтын хөтөлбөр нь цаасан дээр хэрхэн боловсруулагдсан байхаас гадна багш нарын хэрэгжүүлж буй практик үйл ажиллагаа, хэрэглэгдэхүүн, сургалтын орчны нөлөөллийг судлах шаардлагатай. www.inews.mn/greensoft.mn.
2. Хөтөлбөрөө ойлгож амжаагүй багшийн хувьд сурагч болон эцэг эхтэй хөтөлбөрийн зорилго, аргыг ойлгуулах боломж хязгаарлагддаг бөгөөд энэ нь сургалтын амжилтыг бууруулж, бухимдал үүсгэх асуудалтай. www.inews.mn.

Судалгааны арга

Баримт өгөгдлийг боловсруулах үр дүнг тооцох Excel, статистикийн арга

Үндсэн хэсэг гарчиг 1

Монгол, Япон улсын бага боловсролын хөгжмийн хөтөлбөрийн шинэчлэлийн үзэл баримтлал, арга зүй, агуулга, мэдлэг, чадвар, хандлагыг харьцуулан судлахад оршино.

Монгол улсын бага боловсролын хөгжмийн сургалтын хөтөлбөр нь:

- Зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээ, сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг тусгасан цогц баримт бичиг
- **Хөгжмийн боловсрол** болон ерөнхий боловсролын түвшинтэй, тус бүрт нь хамаарах судлагдахууны хөтөлбөртэй
- Чадамжид суурилсан

Сургуулийн өмнөх боловсролоос эхлэн, цахим технологийн энгийн төсөөлөл, бага боловсролоос эхлэн компьютерын ухааныг судална. Бага боловсролын төгсгөл шатлалаас англи хэл, суурь боловсролд бусад гадаад хэлийг сонголттой судална.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хуулийн 20.6-д заасны дагуу ахлах ангийн сургалтын хөтөлбөр сонгон судлах төрөлтэй байна. Сонгон судалсан сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг үндэслэн, ахлах ангийн суралцагчдад хөдөлмөрийн зах зээлд гарах нөхцөл, боломжийг бүрдүүлнэ гэж үзжээ.

Монгол улсын (2019) бага боловсролын хөгжмийн сургалтын хөтөлбөрийн арга зүйд “Сурагчийн эзэмшвэл зохих тодорхой мэдлэг, чадвар, хандлагад баримжаалан сурах арга барилын эзэмшилт болон авьяас чадварыг хөгжүүлэхтэй холбогдуулж, дараах зүйлийг анхаарч ажиллана. Үүнд: - Урлагийн олон талт үйл ажиллагааг бие даасан болон хамтарсан хэлбэрээр гүйцэтгэх, үйлийн явцад суралцах, энгийнээс аажмаар өргөжин гүнзгийрэх арга зүйд суурилна. - Урын сангийн сонголтыг

оновчтой хийж, сурагч бүрийн авьяасыг хөгжүүлэхийн тулд илэрхийлэх арга хэлбэрийг чөлөөтэй сонгох боломж олгох, сургууль болон сурагчийн нөхцөл байдалд тохируулан үр дүнтэй заах арга зүйг боловсруулахыг чухалчилна. - Өөрийн болон бусад улс орны дүрслэх урлаг, дуу хөгжим, технологийн сургалтын хөтөлбөрийн зорилготой уялдуулан сурагчдад ойлгоход дөхөм, сонирхол, эрэлт хэрэгцээнд нь нийцсэн урлагийн бүтээлийг сонгоно. - Сурагчдын эрэлт хэрэгцээ сонирхлыг харгалзан театр музей, галерей, үзэсгэлэн үзүүлж, монгол ардын болон сонгодог, орчин үеийн урлагийн бүтээлүүдтэй танилцах боломжийг бүрдүүлж, соёлын өв, урлагийн үнэт бүтээлүүдийг хүндэтгэх, хамгаалах төлөвшил олгоход анхаарна. - Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй, технологи нь сурагч мэдлэг бүтээх идэвхтэй сургалтын аргад тулгуурласан, сурагчдын ялгаатай байдлыг тооцсон, өөртөө итгэлтэй, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, тайлбарлах зэрэг чадварт суралцахад чиглэнэ” гэж тусгажээ.

Үндсэн хэсэг гарчиг 2

Монголын боловсролын алсын хараа (2024-2036) баримт бичигт “Хүн төрөлхтний нийтлэг соёлыг хүндэтгэх, ардчилсан, хүмүүнлэг, иргэний нийгмийг цогцлоох, гэр бүлийн амьдралын баталгаа болох, хувь хүний хөгжлийг дэмжих, монгол хүнийг төлөвшүүлэх, мэдээлэл технологийн дэвшилд тулгуурласан хөгжил нь бидний урьд өмнө байгаагүй шинэ боломжуудыг бий болгож байна. Бид түүнийг боловсролынхоо үр ашгийг дээшлүүлэхэд ашиглах болно” гэж тусгажээ.

Монголын боловсролын үнэт зүйл: Дэлхийн соёл, гэр бүл, суралцахуй, монгол сэтгэлгээ үнэт зүйл гэж үзсэн байна.

Монголын боловсролын тэргүүлэх чиглэл: Хүн бүрт Монгол суралцагчийн дүр төрхийг бүтээхэд сургалтын хөтөлбөр, хүний нөөц, боловсролын орчин, удирдлага зохион байгуулалт, үнэлгээ мониторинг тэргүүлэх чиглэлээр тодорхойлж байна (тогтоол, 2023)

Хүснэгт 1. Суралцагчийн эзэмших чадамж

Суурь чадамж	Эх хэл, бичиг үсэг Математик Шинжлэх ухаан (байгалийн ба нийгмийн) Компьютерын ухаан ба цахим технологи Англи хэл болон бусад гадаад хэл Биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдал
Ерөнхий чадамж	Бүтээлчээр, шүүн тунгаах сэтгэлгээ Суралцах арга барил Харилцаа, хамтын ажиллагаа Нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил Тогтвортой хөгжил Үндэсний болон дэлхийн өв соёл

Сургалтын хөтөлбөрөөр сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын зорилгод нийцсэн мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийн цогц чадамжийг Монгол суралцагчид эзэмшүүлэх бөгөөд чадамж нь дараах суурь болон ерөнхий чадамжаас бүрдэнэ.

Япон улсын бага сургуулийн хөтөлбөрийн ямар зүйлсийг харгалзан үзэж сургалтын удирдамжийг шинэчилсэн бэ? (2020-2024);

1. “Юу хийж чаддаг болох вэ?” (Хөгжүүлэхийг зорьсон чадвар, чадамж)
2. “Юу сурах вэ?” (Судлах хичээлийн ач холбогдол болон хичээл хоорондын болон сургуулийн түвшний уялдаа холбоонд суурилсан боловсролын хөтөлбөрийн зохион байгуулалт)
3. “Хэрхэн сурах вэ?” (Хичээл тус бүрийн сургалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, суралцах үйл явцыг сайжруулах, боловсронгуй болгох)
4. “Хүүхдийн хөгжлийг хэрхэн дэмжих вэ?” (Хүүхдийн хөгжлийн онцлогт нийцүүлэн заах арга барил)
5. “Юу эзэмшсэн бэ?” (Суралцахуйн үнэлгээний сайжруулалт)
6. “Үүнийг хэрэгжүүлэхэд юу шаардлагатай вэ?” (Сургалтын удирдамжийн үзэл санааг бодит хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ)

Энэ удаагийн шинэчлэлээр амьдрал, нийгэм дэх хөгжимтэй баялаг харилцаатай байх чадварыг төлөвшүүлэх зорилтыг тодорхой болгож, дараах гурван чадамжийг хөгжүүлэхийг зорьж байна.

1. Мэдлэг, ур чадвар эзэмших
2. Сэтгэн бодох чадвар, шүүн тунгаах чадвар, илэрхийлэх чадварыг хөгжүүлэх
3. Суралцах хандлага, хүнлэг чанарыг төлөвшүүлэх
4. Сурагчдыг хөгжмийн боловсролоор хэрхэн төлөвшүүлэх вэ?
5. Хүүхдүүдэд юу зааж, юуг ойлгуулах вэ?
6. Хөгжлийн үе шат, цаг хугацаанд нь тохируулан сургалтын агуулга болон сургалтын материалыг хэрхэн сонгох, заах вэ?

Сургалтын удирдамж дахь хичээлийн зорилго

Илэрхийлэх болон сонсох үйл ажиллагааны тусламжтайгаар хөгжмийн талаарх харах, бодох чадварыг ажиллуулж, амьдрал болон нийгэм дэх дуу авиа, хөгжимтэй баялаг харилцаатай байх чадвар, чадамжийг дараах байдлаар хөгжүүлэхийг зорьж байна.

1. Хөгжмийн агуулга болон бүтцийн уялдаа холбоог ойлгож, өөрийн илэрхийлэхийг хүссэн хөгжмийн илэрхийллийг хийхэд шаардлагатай ур чадвар эзэмших
2. Хөгжмийг бүтээлчээр илэрхийлэх арга замыг эрэлхийлэх, мөн хөгжмийг таашаан сонсох чадварыг хөгжүүлэх.
3. Хөгжмийн үйл ажиллагааны хөгжилтэй байдлыг мэдрэх замаар хөгжмийг хайрлах сэтгэл, хөгжмийн мэдрэмжийг төлөвшүүлэхийн зэрэгцээ хөгжимд дуртай байх хандлага, уран сайхны мэдрэмжийг хөгжүүлэх.






Сургалтын удирдамжийн агуулгын бүтэц, хөгжмийн хичээлийн агуулга нь дараах гурван хэсгээс бүрдэнэ.

- Илэрхийлэл (表現)
- Б. Сонсож ойлгох (鑑賞)
- В. Нийтлэг асуудал (共通事項)

Мөн эдгээр чадамжийг хөгжүүлэхийн тулд хөгжмийн талаарх харах, бодох чадварыг ажиллуулах нь чухал болохыг онцолж байна

Хүснэгт 2. Суралцагчдад эзэмшүүлэх мэдлэг, чадвар, хандлага

	Бага анги (1, 2-р анги)	Дунд анги (3, 4-р анги)	Ахлах анги (5, 6-р анги)
Зорилго	(1) Хөгжмийн уран сэтгэмж ба хөгжмийн бүтэц хоорондын холбоог ойлгож, хөгжмийн илэрхийллийг сонирхон үзэхийн тулд шаардлагатай дуулалт, хөгжмийн зэмсэг, хөгжмийн бүтээлч илэрхийллийн ур чадварыг эзэмших	(1) Хөгжмийн уран сэтгэмж ба хөгжмийн бүтэц хоорондын холбоог ойлгож, хүссэн хөгжмийн илэрхийллээ гаргахын тулд шаардлагатай дуулалт, хөгжмийн зэмсэг, хөгжмийн бүтээлч илэрхийллийн ур чадварыг эзэмших	(1) Хөгжмийн уран сэтгэмж ба хөгжмийн бүтэц хоорондын холбоог ойлгож, хүссэн хөгжмийн илэрхийллээ гаргахын тулд шаардлагатай дуулалт, хөгжмийн зэмсэг, хөгжмийн бүтээлч илэрхийллийн ур чадварыг эзэмших
Дуулалт	И. Хөгжмийн уран сэтгэмж ба хөгжмийн бүтэц, дууны үгний дүрслэл болон сэтгэл хөдлөлийн уялдаа холбоог ойлгох	И. Хөгжмийн уран сэтгэмж, хөгжмийн бүтэц болон дууны үгийн утгын уялдаа холбоог ойлгох	И. Хөгжмийн уран сэтгэмж, хөгжмийн бүтэц болон дууны үгийн утгын уялдаа холбоог ойлгох
Хөгжмийн зэмсгийн илэрхийлэл	И. Дараах (ᠠ) болон (ᠠ)-ийн талаар ойлголттой болох (ᠠ) Хөгжмийн уран сэтгэмж ба хөгжмийн бүтэц хоорондын уялдаа холбоо (ᠠ) Хөгжмийн зэмсгийн өнгө, дуугаралт ба тоглох арга барилын уялдаа холбоо	И. Дараах (ᠠ) болон (ᠠ)-ийн талаар ойлголттой болох (ᠠ) Хөгжмийн уран сэтгэмж ба хөгжмийн бүтэц хоорондын уялдаа холбоо (ᠠ) Хөгжмийн зэмсгийн өнгө, дуугаралт ба тоглох арга барилын уялдаа холбоо	И. Дараах (ᠠ) болон (ᠠ)-ийн талаар ойлголттой болох (ᠠ) Хөгжмийн уран сэтгэмж ба хөгжмийн бүтэц хоорондын уялдаа холбоо (ᠠ) Олон төрлийн хөгжмийн зэмсгийн өнгө, дуугаралт ба тоглох арга барилын уялдаа холбоо
Хөгжим бүтээх (Бүтээлч илэрхийлэл)	И. Дараах (ᠠ) болон (ᠠ)-ийг хөгжмийн сонирхолтой байдалтай холбон ойлгох (ᠠ) Дуу хоолой болон орчны дуу чимээний онцлог (ᠠ) Дуу авиаг холбох арга барилын онцлог	И. Дараах (ᠠ) болон (ᠠ)-ийг хөгжмийн гоо сайхан, сонирхолтой байдалтай холбон ойлгох (ᠠ) Янз бүрийн дуу авиа, тэдгээрийн хослолын онцлог (ᠠ) Дуу авиаг холбох болон давхарлах арга барилын онцлог	И. Дараах (ᠠ) болон (ᠠ)-ийг хөгжмийн гоо сайхан, сонирхолтой байдалтай холбон ойлгох (ᠠ) Янз бүрийн дуу авиа, тэдгээрийн хослолын онцлог (ᠠ) Дуу авиаг холбох болон давхарлах арга барилын онцлог

	Бага анги (1, 2-р анги)	Дунд анги (3, 4-р анги)	Ахлах анги (5, 6-р анги)
Сонсох, үнэлэх (Сонголын боловсрол)	И. Хөгжмийн уран сэтгэмж ба хөгжмийн бүтэц хоорондын холбоог ойлгох	И. Хөгжмийн уран сэтгэмж ба түүний өөрчлөлт болон хөгжмийн бүтэц хоорондын холбоог ойлгох	И. Хөгжмийн уран сэтгэмж ба түүний өөрчлөлт болон хөгжмийн бүтэц хоорондын холбоог ойлгох
Нийтлэг зүйлс	<p>И. Хөгжмийг бүрдүүлж буй элементүүд болон тэдгээртэй холбоотой дуу авианы бүтэц, завсарлага, тэмдэг, нэр томъёог хөгжмийн үүрэгтэй холбон ойлгох.</p> <p>(9) Анги бүрийн (Нийтлэг зүйлс) (1)-ийн И хэсэгт дурдсан “дуу авианы бүтэц, завсарлага, тэмдэг, нэр томъёо»Сурагчдын түвшин, сургалтын явцтай уялдуулан эдгээрийг хөгжмийн үүрэгтэй холбон ойлгож, ашиглах боломжийг хангах.</p>  <p>     </p>		

Сурагчдыг хөгжмийн боловсролоор хэрхэн төлөвшүүлэх вэ?

Хүүхдүүдэд юу зааж, юуг ойлгуулах вэ?

Хөгжлийн үе шат, цаг хугацаанд нь тохируулан сургалтын агуулга болон сургалтын материалыг хэрхэн сонгох, заах вэ? Үүнээс харахад, хөгжим зохиох болон сонсож ойлгох үйл ажиллагааны тусламжтайгаар хөгжмийн талаарх харах, бодох чадварыг ажиллуулж, амьдрал болон нийгэм дэх дуу авиа, хөгжимтэй баялаг харилцаатай байх чадвар, чадамжийг дараах байдлаар хөгжүүлэхийг зорьж байна. Үүнд:

1. Хөгжмийн агуулга болон бүтцийн уялдаа холбоог ойлгож, өөрийн илэрхийлэхийг хүссэн хөгжмийн илэрхийллийг хийхэд шаардлагатай ур чадвар эзэмших
2. Хөгжмийг бүтээлчээр илэрхийлэх арга замыг эрэлхийлэх, мөн хөгжмийг таашаан сонсох чадварыг хөгжүүлэх
3. Хөгжмийн үйл ажиллагааны хөгжилтэй байдлыг мэдрэх замаар хөгжмийг хайрлах сэтгэл, хөгжмийн мэдрэмжийг төлөвшүүлэхийн зэрэгцээ хөгжимд дуртай байх хандлага, уран сайхны мэдрэмжийг хөгжүүлэх

Хүснэгт 3. Харьцуулсан судалгаа

Улс	Үзэл баримтлал	Агуулга	Мэдлэг	Чадвар	Хандлага
Монгол (2024)	Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал (2024-2036) зорилго нь суралцагчийн эзэмших чадамжийг тодорхойлж, эзэмшүүлэх сургалтын хөтөлбөр, судлагдахууны хөтөлбөрийн агуулгын залгамж холбоо, арга зүй, үнэлгээний нийцтэй байдлыг харгалзан боловсруулах үйл ажиллагааг чиглүүлэхэд оршино	Илэрхий агуулга тодорхойгүй, суралцахад чиглэсэн	Мэдлэг төвлөрсөн	Чадварын зарчим суурилсан (имплицит)	Суралцах үйл явцад төвлөрсөн, зохион байгуулалтын хандлага
Япон (2020)	Хөгжмийн мэдрэмжийг хөгжүүлэх, бусадтай хамтран ажиллан хөгжим бүтээх, хөгжим сонсохдоо түүний сайхныг ойлгох чадвартай болох нөхцлийг бүрдүүлэх. Дуу чимээ, хөгжимтэй өөрийгөө хэрхэн холбож буйгаа ойлгож, амьдрал, нийгэм дэх хөгжим, дуу чимээний үүрэг, ач холбогдлыг ухамсарлах чадварыг хөгжүүлэх. Өөрийн орны болон орон нутгийн хөгжмийн урлагт дуртай болох, түүний үнэ цэнийг гүнзгий ойлгох зорилгоор үндэсний хөгжмийг (вагакү - япон үндэсний хөгжим) судлах боломжийг нэмэгдүүлэх.	Сольфеж, үнэлгээ, сонсох чадвар, бүтээлч	Сольфеж, хөгжим ойлгох, бүтцийн мэдлэг	Сонсох, дуулах, бүтээлч илэрхийлэл	Бие даасан хөгжлийн хандлага, урлагийн мэдрэмж, хамтран бүтээлтэн

Монголын хөтөлбөрт хөгжмийн хичээлийн агуулга нь үндэсний онцлог, ардын урлагийг түлхүү тусгасан бөгөөд 2024 оны шинэчлэлд хичээл хоорондын уялдаа, залгамж чанарыг сайжруулах зорилго тодорхой харагддаг. Японы хөтөлбөрт хичээлийн агуулга нь нот унших, дуулах, хөгжим тоглох, хөгжмийн бүтцийг ойлгох зэрэг нарийн задалсан бүтэцтэй бөгөөд сурагчийн бүтээлч илэрхийлэл, гоо зүйн боловсролд илүү анхаарсан байна.

Судалгааны үр дүн

Энэхүү судалгаанд Монгол, Япон улсын бага боловсролын хөгжмийн хөтөлбөрийн шинэчлэлийн үзэл баримтлал, агуулга, мэдлэг, чадвар, хандлагын чиглэлүүдийг харьцуулан баримт бичгийн шинжилгээний аргаар судалсан. Судалгааны үр дүнг дараах үндсэн чиглэлүүдээр эмхэтгэн дүгнэв.

- **Монгол 2019:** Хөгжлийн эхлэл. Агуулгыг оновчтой болгох замаар чанарыг нэмэхэд анхаарсан
- **Монгол 2024:** Бодит хэрэгжилтэд чиглэсэн, чадамжийн төлөвшилд суурилсан шинэчлэлт, тэгш хүртээмж болон насан туршийн боловсролыг тусгасан.
- **Япон 2020:** Урлагийн гүн мэдрэмж, бүтээлч илэрхийлэл, хөгжмийн мэдрэмжийн эрх чөлөөг дээдэлсэн боловсролын үзэл баримтлал.

Дүгнэлт

Хоёр улсын хөгжмийн хөтөлбөрийн шинэчлэлийн чиг хандлага нь өөр өөр зорилт, арга зүйд тулгуурлаж буй боловч сурагчийн хөгжлийг төвд тавьсан, чанартай боловсрол олгох нийтлэг зорилгыг агуулж байв. Монгол Улс нь боловсролын бодлого, үзэл баримтлалын түвшинд шинэчлэл хийж буй бол Япон Улс нь хөтөлбөрийн гүйцэтгэлийн нарийвчлал, агуулгын уялдаа, суралцахуйн гүнзгийрэлд түлхүү анхаардаг байна. Судалгааны гол зорилго нь хоёр улсын хөгжмийн хөтөлбөрийн шинэчлэлийн чиг хандлага, агуулга, боловсруулалтын арга зүйг шинжлэх ухааны үндэслэлтэй харьцуулан дүгнэхэд оршсон. Судалгааны үр дүнд:

- Хоёр улсын хөтөлбөрийн суурь үзэл баримтлал, боловсруулалтын арга зүйн онцлогийг системтэйгээр харьцуулж, сургалтын зорилго, хандлага, үнэлгээ, хэрэгжилтийн түвшинд ялгааг тодорхойлж чадсан;
- Монголын сургалтын шинэчилсэн хөтөлбөр нь бодлогын түвшинд чадамжид суурилсан, суралцагч төвтэй, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн шинэчлэлийн загвар болохыг чухалчилсан бол Японы хөтөлбөр нь урлагийн мэдрэмж, гоо зүйн боловсролд суурилсан тогтвортой сургалтын бүтэцтэй болохыг батлан харуулсан байна.
- Хөтөлбөрийн мэдлэг, чадвар, хандлагын хэмжээнд хоёр улсын хөтөлбөрийн боловсруулалт, арга зүй, үнэлгээний хандлагыг судлах нь бидний судалгааны зорилго гэж үзэж байна. Тиймээс судлах асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, баримт бичгийн шинжилгээний арга зүйд тулгуурлан, **онолпрактикийн түвшинд судалсан** гэж дүгнэж байна.

Хөтөлбөрийн шинэчлэлийн эрдэмтэн судлаачдад хандан санал болгох нь Дээрх асуудлууд нь зөвхөн боловсролын бодлого төдийгүй хөгжмийн урлаг, гоо зүйн хүмүүжил, соёлын үнэт зүйлийг дамжуулах боловсролын үндэс суурийг бүрдүүлэх тул цаашид энэ сэдвийн хүрээнд:

- Харьцуулсан боловсрол судлал,
- Хөтөлбөр боловсруулах арга зүй,
- Урлагийн боловсрол дахь чадамжид суурилсан үнэлгээ,
- Үндэсний болон олон улсын сургалтын жишиг харьцуулалт зэрэг чиглэлээр гүнзгийрүүлсэн, туршилтсудалгаанд суурилсан ажил хийх нь ач холбогдолтой гэж үзэж байна.

Ном зүй

1. Монгол улсын засгийн газрын тогтоол . (Улаанбаатар оны 2024 04.24). <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140353213781>: Дугаар 176-ээс Гаргасан
2. Монгол улсын их хурал. (n.d.). Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=206661>.
3. сургууль, М. у. (2013). Боловсролын онол, арга зүйн зарим асуудал. Лавай №9, х.56. БСШУЯ. (2019). Бага боловсролын сургалтын хөтөлбөр. Улаанбаатар.
4. Япон Улсын Боловсрол Шинжлэх ухааны яам (2017). Бага сургуулийн сургалтын заах агуулгын тайлбар
5. Ёкохама хотын Боловсролын хороо, (2017). Ёкохама хотын сургуулийн хөтөлбөр, менежментийн агуулга ,дуу хөгжим.
6. Батсүх,Ч. (2011). Хөгжим гоо зүйн боловсролд: хөгжмийн сургалтын технологийн шинэчилэл. Улаанбаатар. Адмон
7. Монгол улсын засгийн газрын тогтоол . (Улаанбаатар оны 2024 04.24). <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140353213781>: Дугаар 176-ээс Гаргасан
8. Монгол улсын их хурал. (n.d.). Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=206661>.
9. сургууль, М. у. (2013). Боловсролын онол, арга зүйн зарим асуудал. Лавай №9, х.56.
10. тогтоол, З. г. (2023 оны Улаанбаатар 03). <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16758861285151>. 29-ээс Гаргасан
11. тогтоол, М. у. (2024 оны 04 24). <https://cdn.greensoft.mn/uploads/users/2760/>. дугаар 176-ээс Гаргасан

CURRICULUM REFORM OF MUSIC EDUCATION IN PRIMARY SCHOOLS IN MONGOLIA AND JAPAN

^aZayabat G., ^bOtgonbayar Ch., ^cHisako Watanabe

^aPh.D, Teachers school, MNUE;

^bPh.D, Teachers school, MNUE;

^cTeachers school, MNUE

Corresponding author: zasaba@msue.edu.mn 

Abstract

Today, countries around the world are aligning their education policies toward cultivating individuals who possess the knowledge, skills, and values necessary to solve global challenges—creative citizens equipped for lifelong learning. Achieving this vision requires not only curriculum reform, but also a shift in mindset at all levels of education. International trends in teacher education emphasize the development of human-centered, open, and flexible systems, aiming to enhance the effectiveness and impact of teaching. Within this context, the shared goal of “*improving school education to build a better society*” is being pursued through active cooperation among schools, families, and local communities. Such collaboration is increasingly seen as essential for equipping students with the competencies needed for the new era. Accordingly, educational curricula are being redesigned under the concept of “**open education curricula**”, which promote learner-centered approaches and encourage broad stakeholder engagement. In line with this global movement, the primary school music curricula of Mongolia and Japan have been revised to reflect a more integrated approach that combines knowledge, skills, and attitudes as core elements of student development (School, 2013).

Keywords

Curriculum, music, competency, program, child, skill
